



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2022 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр


Дугаар 48

Улаанбаатар
хот

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн,
дүрэм шинэчлэн батлах тухай


1. “Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 1 дүгээр хавсралт, “Сансрын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 85 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Ерөнхий сайдын 2022 оны 48 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

САНСРЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Цахим хөгжил, харилцаа холбооны сайд
- Дэд дарга: -Боловсрол, шинжлэх ухааны сайд;
-Монгол Улсын сансрын нисгэгч.
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх;
-Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;
-Батлан хамгаалахын дэд сайд;
-Барилга, хот байгуулалтын дэд сайд;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
-Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;
-Эрчим хүчний дэд сайд;
-Эдийн засаг, хөгжлийн дэд сайд;
-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга (зөвшилцсөнөөр);
-Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга;
-Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Сансрын холбооны хэлтсийн дарга;
-Тагнуулын ерөнхий газрын дарга;
-Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
-Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
-Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга;

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга;
- Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
- Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал;
- Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн захирал;
- Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Зайнаас тандан судлалын хэлтсийн дарга;
- Монгол Улсын их сургуулийн захирал;
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал;
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн дэд захирал;
- Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал;
- “Монголсат Нетворк” ХХК-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- “ДДэш” ХХК-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- “МонМэп” ХХК-ийн ерөнхий захирал (тохиролцсоноор);
- “Монголын сансрын технологийн холбоо” ТББ-ын тэргүүн (тохиролцсоноор);
- “Монголын гео-мэдээллийн холбоо” ТББ-ын тэргүүн (тохиролцсоноор);
- “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” ТББ-ын тэргүүн (тохиролцсоноор);
- “Монголын сансрын судалгаа, хөгжүүлэлтийн төв” ТББ-ын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- “Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци” ТББ-ын тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн дарга.

---o0o---

Ерөнхий сайдын 2022 оны 48 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

САНСРЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Сансрын үндэсний зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн зорилго нь Монгол Улсад сансар судлал, сансрын технологийн салбарыг хөгжүүлэх, төрийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр.Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1.Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2.Зөвлөлийн гишүүд нь холбогдох төрийн байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.3.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын саналаар зарлан хуралдуулна.

2.4.Зөвлөлийн даргын эзгүйд хуралдааныг дэд дарга даргална.

2.5.Зөвлөл нь тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

2.6.Зөвлөл нь өөрийн эрх хэмжээний хүрээнд санал, зөвлөмж гаргана.

Гурав.Зөвлөлийн чиг үүрэг

3.1.Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.сансар судлал, сансрын технологийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулахад мэргэжил, арга зүйгээр хангаж, санал, зөвлөмж өгөх;

3.1.2.сансар судлалын талаарх урт хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар санал гаргах;

3.1.3.сансар судлал, сансрын технологийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулах, судалгааны ажил хийхэд салбарын эрдэмтэн, судлаачдыг холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах;

3.1.4.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн тайлантай танилцах, цаашид авах арга хэмжээний санал гаргах;

3.1.5.зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагаас зохих журмын дагуу гаргуулан авах;

3.1.6.сансар судлал, сансрын технологийн салбарыг хөгжүүлэх асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал боловсруулах.

3.2.Зөвлөлийн гишүүн дор дурдсан эрх, үүрэгтэй:

3.2.1.зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах;

3.2.2.хуралдаанаар хэлэлцэх асуудлын материал, мэдээллийн эх сурвалжийг зөвшөөрөлгүйгээр хувилах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;

3.2.3.төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, түүний явц, үр дүнгийн талаар зөвлөлийн хуралдаанд мэдээлэх.

Дөрөв.Зөвлөлийн ажлын алба

4.1.Зөвлөлийн ажлын албаны үүргийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сансрын холбооны асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

4.2.Зөвлөлийн ажлын албыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга удирдана.

4.3.Ажлын алба нь дараахь чиг үүрэгтэй байна:

4.3.1.зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.3.2.зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

4.3.3.зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгаа, тодорхойлолтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах.

Тав.Бусад зүйл

5.1.Зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүрийн эхний улиралд Засгийн газарт танилцуулна.

5.2.Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, бусад баримт бичгийг ажлын алба зохих журмын дагуу архивын нэгж болгон хадгална.